

Ээлжит хичээлийн хөтөлбөр - 4

Хамрах хүрээ: 6-р анги

Сэдэв: Эргүүлэлт

Хугацаа: 40 минут

Зорилго: Өгсөн цэг дээр төвтэй цагийн зүүний дагуу болон эсрэг чиглэлд 90° , 180° , 270° -аар эргүүлж сурна.


Зорилт:

- Эргэлтийн тэгш хэмийн эрэмбийголох
- Дүрсийг эргүүлэлт хувиргалтаар хувиргах

Агуулга:

Өмнө судлагдсан агуулга	Цаашид судлах агуулга
Судлагдаж байгаагүй.	Эргүүлэлт хувиргалтын шинж чанарыг судлана.

Цагийн төлөвлөлт:

	Багшийн үйл ажиллагаа	Сурагчийн үйл ажиллагаа
Сэдэлжүүлэлт 5 мин	Салхин сэнс ямар хөдөлгөөн хийдэг юэ? Одоо бүгдээрээ цаасаар салхин сэнс хийцгээе!	Эргүүлэлт
Шинэ мэдлэг бүтээх / 25мин/	<p>Алхам 1 Цаасан сэнсний оройг А,Б,В,Г үсгээр тэмдэглэцгээе. Цаасан сэнсний төвтэй эргүүлэе.</p> <ol style="list-style-type: none"> 1. А үсгийн оройг цагийн зүүний дагуу эргүүлэхэд Г үсгийн байрлал дээр очсон бол хэдэн градусаар эргүүлсэн бэ? 2. А үсгийн оройг цагийн зүүний дагуу 90° градусаар хэдэн удаа эргүүлвэл Б үсгийн байрлал дээр очих вэ? 3. А үсгийн орой Б үсгийн байрлал дээр очсон бол цагийн зүүний эсрэг хэдэн градусаар эргэсэн бэ? 4. А үсгийг ахин цагийн зүүний эсрэг 90° градусаар эргүүлнэ үү? <p>Алхам 2</p> <ul style="list-style-type: none"> - Үйлдлийг хялбарчлан А үсгийн оройг цагийн зүүний эсрэг эргүүлэн Г үсгийн байрлал дээр аваачсан бол хэдэн градусаар эргүүлснийг ярилца. - Үйлдлийг хялбарчлан А үсгийн оройг цагийн зүүний эсрэг эргүүлэн В үсгийн байрлал дээр аваачсан бол хэдэн градусаар эргүүлснийг ярилца. 	<p>Алхам 1</p> <ol style="list-style-type: none"> 1. 90° градусаар 2. 2 удаа 3. 90° градус 4. 2 удаа <p>Алхам 2 Эдгээр эргүүлэлтүүд нь бүгд цаасан сэнсний төвтэй эргүүлэлт гэдгийг ойлгох</p>
Бататгал	Өгөгдсөн ABC гурвалжныг 90° , 180° , 270° -аар цагийн зүүний эсрэг эргүүлнэ үү	

Дүгнэлт /10 мин /	Асуулт 90 градусаар 3 удаа эргүүлэх нь хэдэн градусаар эргүүлсэнтэй адил вэ?	270 градусаар эргүүлсэнтэй адил байна.
----------------------	---	--

Алхам 1

Цаасан сэнсний оройг А,Б,В,Г үсгээр тэмдэглэцгээе. Цаасан сэнсний төвтэй эргүүлэе.

5. А үсгийн оройг цагийн зүүний дагуу эргүүлэхэд Г үсгийн байрлал дээр очсон бол хэдэн градусаар эргүүлсэн бэ?
6. А үсгийн оройг цагийн зүүний дагуу 90 градусаар хэдэн удаа эргүүлвэл Б үсгийн байрлал дээр очих вэ?

Алхам 2

Үйлдлийг хялбарчлан А үсгийн оройг цагийн зүүний эсрэг эргүүлэн Г үсгийн байрлал дээр аваачсан бол хэдэн градусаар эргүүлснийг ярилцаая.

Асуулт

90 градусаар 3 удаа эргүүлэх нь хэдэн градусаар эргүүлсэнтэй адил вэ?

Хэрэгдэгдэхүүн:

